



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 03 сарын 03 өдөр

Дугаар A/09

Улаанбаатар хот

┌ Өндөржүүлсэн бэлэн байдлын үед авч ┐  
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай” 10 дугаар зарлиг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 30, 39, 62, 63 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын 2020 оны тогтоол, шийдвэрүүд, Нийслэлийн Засаг даргын 2020 оны A/108, A/166, A/168, A/191, A/286 дугаар захирамж, Нийслэлийн Онцгой комиссын даргын 01,02 дугаар тушаал, Нийслэлийн онцгой комиссын 07 дугаар хурлын тэмдэглэл, “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6, Хөдөлмөрийн дотоод журмын 3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжиж, ажлын тусгай горимоор ажиллаж байгаатай холбогдуулан 24 цагаар утсаа нээлттэй байлгах, ажилдаа хариуцлагатай хандах, төрийн болон хувийн ажлаар гадаад улс орнууд, орон нутаг руу явахгүй байх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.


2. Сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл түр хугацаагаар зогсоосонтой холбогдуулан 12 хүртэлх насны хүүхэдтэй алба хаагчид / эхчүүд/-ийн ажлын цагийг 1 цагаар хорогдуулж 09:00-17:00 цагийн хооронд ажиллуулсугай.

3. 12 хүртэлх насны хүүхэдтэй албан хаагчдын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

4. Ажлын цаг хорогдуулан ажиллаж байгаа албан хаагчдын цалин хөлсийг ажилласанд тооцон зохих журмын дагуу олгохыг Нягтлан бодогч / Г.Баярмаа/ -д зөвшөөрсүгэй.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг орлогч дарга /З.Очирбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ХАТАНБААТАР

215030264